



Г "ДАРХАН-УС СУВАГ" ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ЭРДЭНЭБЛЯР-Г

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА,
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

915 Дархан, Дархан-Уул аймаг
Утас: 7037-3089, Факс: 7037-3089

2014.04.08 № 226

танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15.2, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу "Дархан-Ус суваг" ХК-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулгад аудит хийв.

"Дархан-Ус суваг" ХК-ийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайланг хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу болгож, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан Нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Дархан-Ус суваг" ХК-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ОТГОНСҮХ